

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 05 ДУГААР САРЫН  
2 ДАХЬ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ**

2018.05.10

	Хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэв эл зохих асуудал	Бусад асуудал
1	<p>Баян-Өлгий аймгийн Засаг даргын Мөрийн хөтөлбөр болон БОАЖГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Дэлхийн байгаль хамгаалах сан, Цагдаагийн газар, Прокурорын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, МАНУТХГазар, Хөх Сэрхийн ДЦГазар, Ус, цаг, уур орчны шинжилгээний алба зэрэг байгууллагууд хамтран <b>“ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН”</b>-ийг ХИС-ийн аймаг дахь салбар сургуулийн хурлын танхимд байгаль орчны ажилтнуудад зохион байгууллаа.</p> <p>Зөвлөгөөнд дээрх байгууллагуудын төлөөллүүдээс бүрдсэн 150 гаруй хүн оролцов. Байгаль орчны талаар шинэчлэгдэн батлагдсан хуулиуд болон тэдгээртэй холбоотой гарсан дүрэм журам, зааврын хэрэгжилтийг хангуулах талаар болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох түүнийг шийдвэрлэхэд хууль, хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, салбарын гарч буй хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж гарган аймгийн ИТХ-д оруулахаар хэлэлцэв .</p> <p>Зөвлөгөөний нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга А.Гылымхан оролцож, байгаль хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулсан зарим идэвхтэн байгаль хамгаалагч нарыг аймгийн Засаг даргын нэрэмжит “ Хүндэт тэмдэг”, “Тэргүүний ажилтан” тэмдгээр шагнав.</p>		
2	<p>ЭрчимБаян-Өлгий ХХК-ны Дэлүүн, Улаанхус сумд зуух ажилуулах, Алтай сумд худалдаа үйлчилгээ явуулдаг 5 иргэний төсөлд БОНБЕҮнэлгээний дүгнэлт гаргав.</p>		
3	<p>Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр Алтай сумын алслагдсан баг болох УЛААН ХАД багт ирвэс хамгаалах, түүний идэш ан амьтадыг хамгаалах, иргэдийн оролцоотой байгаль хамгаалах зөв зохистой менежмент бий болгох зорилгоор тус багт ДЭЛХИЙН байгаль хамгаалах сангийн ХОВД аймгийн салбарын ажлын хэсэг болон сумын удирдалгуудад хамтран судалгааны ажлаа эхлэхээр иргэдтэй уулзалт хийж ажиллав.</p>		

4	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүр хавар бүх нийтээр мод тарих өдөрийг энэ жил онгоцны буудлын доод талд зохион байгуулахаар Сум дундын ойн ангитай хамтран 1 га газарт хашаа татаж, мод тарих бэлтгэл ажлыг хангаад байна.		
---	--	--	--

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР